# "БУЛГАН АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Булган

| № | Зорилт /бодлогын үндэслэл/ | Төсөл, арга хэмжээ | Төсөв /сая.төг/ | | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | | Хэрэгжилт | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэли |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөсөн | Гүйцэтгэл | Суурь түвшин | Зорилтот түвшин | | |
| 0 | | 1 | 2 | 3.0 | 4 | 5 | 6 | 7 |
| **БҮЛЭГ 1. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| **Зорилт 1.1.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, төлөвшил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцах** | | | | | | | | |
| 1.1.1 | МУХТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.9, ЗДҮАХ-1.2.5 | Хангал сумын 75 ортой цэцэрлэгийн барилга барих | 534.0 | 758.0 | 30 хувийн гүйцэтгэлтэй | Ашиглалтад орсон байна | Цэцэрлэгийн үйл ажиллагаа 2023.10.01-с бүрэн ашиглалтанд орно. Дотор заслын ажил эхэлсэн явагдаж байна. | 90 |
| 1.1.2 | | Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих 280 ор /Булган сум 4 дүгээр цэцэрлэг/ | 4,315.4 | 2,399.4 | Барилгын ажил эхэлсэн | Ашиглалтад орсон байна | Цэцэрлэгийн барилгын ажил 1, 2-р давхрын карказ, цутгалт хийгдсэн дүүргэлтийн ажил явагдаж байна. | 50 |
| 1.1.3 | | Дашинчилэн, Хутаг-Өндөр сумын 150 хүүхдийн дотуур байрны барилгыг дуусгах | 4,600.0 | 2,701.7 | Барилгын ажил эхэлсэн | Ашиглалтад орсон байна | Дашинчилэн сумын дотуур байр нь Барилгын гадна өнгөлгөөний хана, дотор заслын замаскны ажил хийгдэж байна. Хутаг-Өндөр сумын 1, 2-р давхруудын дүүргэлтийн ажил хийгдэж, өрөөний тусгаарлалтын хана өрсөн. 1-р давхрын гадна өрлөг эхэлсэн. | 50 |
| 1.1.4 | | Сэлэнгэ сумын сургуулийн засвар хийх | 250.0 | 246.0 | 50 хувийн санхүүжилтийг 2022 онд шийдвэрлэсэн | Их засварыг хийж дууссан байна | Орон нутгийн төсвийн 246 сая төгрөгний санхүүжилтээр их засварыг бүрэн хийж дууссан. | 100 |
| 1.1.5 | МУХТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.9, ЗДҮАХ-1.2.5 | Дашинчилэн сумын цэцэрлэгт их засвар хийх | 571.7 | 293.8 | Стандарт шаардлага хангахгүй, хүчин чадал хэтэрсэн | Их засварыг хийж дууссан байна | Их засварын ажил хийгдэж дууссан. | 100 |
| 1.1.6 | | Хангал сумын дунд сургууль, их засвар хийх | 392.1 | 224.2 | Стандарт шаардлага хангахгүй | Их засварыг хийж дууссан байна | Орон нутгийн төсвийн 224.2 сая төгрөгний санхүүжилтээр их засварыг бүрэн хийж дууссан. | 100 |
| 1.1.7 | МУХТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.9, ЗДҮАХ-1.2.5 | 2 сумын гэр цэцэрлэгийг шинэчилж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 25.0 | 66.9 | Хөдөөгийн 44 гэр цэцэрлэг ажиллаж байна | 2 сумын гэр цэцэрлэгийг шинэчилж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна | Орон нутгийн төсвийн 66.9 сая төгрөгний хөрөнгөөр Баян-Агт, Гурванбулаг, Могод, Дашинчилэн, Баяннуур, Хутаг-Өндөр, Тэшиг, Рашаант, Бүрэгхангай, Сайхан, Хангал, Орхон 12 сумand 15 гэр цэцэрлэгийг шинэчлэн хүлээлгэн өгсөн. | 100 |
| 1.1.8 | | Боловсролын бүхий л байгууллагуудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 275.0 | 1,146.0 | Өмнөх оноос 21 хувиар нэмэгдсэн | Жил бүр 20-30 хувиар нэмэгдүүлнэ | Сургууль цэцэрлэгийн хүрээнд 3-р улиралд 1,146.0 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Сайдын багцаас ерөнхий боловсролын сургуулийн багш нарт 335 ширхэг нөүтбүүк олгогдож, нийт багш нарын 50%-ийг хамруулаад байна. Лингафонийн танхимд Булган сумын 1-р сургууль, ЭӨЦС, 3-р сургууль, Хутаг-Өндөр, Хялганат сумын ерөнхий боловсролын сургуулиудад 409.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн төсвөөс тус тус хийгдээд байна. | 100 |
| 1.1.9 | ЗДҮАХ – 1.2.4, МУХТЖҮЧ-2.1.7, ЗГҮАХ-2.3.8 | “Шинэ багш” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 50.0 | 274.9 | 82.5% | 90% | "Шинэ багш" хөтөлбөрийн хүрээнд 4 зорилтын 22 арга хэмжээний дагуу "Сургуульд суурилсан менежментийн загвар"-ыг 2 сургуульд туршин хэрэгжүүлж, хувь хүний хөгжлийн 12 модулийн 52 төрлийн цахим болон танхимын сургалт, уулзалтад давхардсан тоогоор 15621 багш, удирдах ажилтныг хамрууллаа. Тухайлбал: Боловсрол судлаач, EDU COACH төслийн санаачлагч Б.Батаа багшийн сургуулийн хөгжил ба удирдлагын менежмент сургалтад боловсролын салбарын 100 удирдах ажилтныг хамруулсны үр дүнд энэ хичээлийн жилд нийт 6 сургууль, 1 цэцэрлэгт менежментийн туршилт хийхээр төлөвлөөд байна. 6 судлагдахууны чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтуудад 464 багш, удирдах ажилтныг хамруулж шинэ хичээлийн жилийн бэлтгэл ажлуудаа хангалаа. Багшийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр тоног төхөөрөмжийн хангалтуудыг үе шаттай хийж, Боловсрол шинжлэх ухааны газрын харьяа багшийн орон сууцны барилгыг эхлүүлж нийт 1 тэрбум 22,7 сая төгрөг зарцуулсан байна. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.10 | ЗДҮАХ – 1.2.1, МУХТЖҮЧ-2.1.3, ЗГҮАХ-2.3.4 | “Шинэ ирээдүй” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 50.0 | 45.0 | 70% | 85% | Үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 1. Бага боловсролын Математикийн масс олимпиадын I давaанд 2-5-р ангийн 4420 суралцагч, II давaанд 2856 суралцагч, Монгол хэл-Унших бичгийн масс олимпиадын I давaанд 4408 суралцагч, II давaанд 2856 суралцагч, Англи хэлний масс олимпиадын I давaанд 32 бүлгийн 780 суралцагч, II давaанд 16 бүлгийн 400 гаруй суралцагч, Математикийн масс олимпиадын I давaанд 6-8-р ангийн 102 бүлгийн 2250 суралцагч, монгол хэлний масс олимпиадад 6-11 дүгээр ангийн 4000 гаруй суралцагч, 200 гаруй бүлэг оролцсон. 2. Аймгийн аварга шалгаруулах "Мэтгэлцээн"-ий тэмцээнийг 2023 оны 05 дугаар сарын 12-нд зохион байгуулж тэмцээнд Баян-Агт, Сайхан, Тэшиг, Хишиг-Өндөр, 1-р сургууль, 3-р сургууль, "Эрдмийн өргөө цогцолбор" сургуулиудын 25-н багийн 75 суралцагчид оролцлоо. Мөн "Оюунлаг Ирээдүй" уран илтгэлийн тэмцээнд Баян-Агт, Сайхан, Тэшиг, Хишиг-Өндөр, Рашаант, Орхон, Хялганат, 1-р сургууль, 3-р сургууль, "Эрдмийн өргөө цогцолбор" сургуулиудын 50 гаруй суралцагч мэдлэг, илтгэх чадвараараа өрсөлдөн эрхээ авлаа. Мөн ЭӨЦС-н Э.Өсөхбаярын бэлтгэсэн 7-р ангийн сурагч Г.Мишээл улсын аваргын "Оюунлаг ирээдүй" илтгэлийн уралдаанд тэргүүн байр эзэлсэн амжилт үзүүлээд байна. 3. Ерөнхий боловсролын сургуулиуд “Хүүхдээ сонсьё” өдрийг сар бүрийн 1-нд зохион байгуулж хэвшсэн. | 80 |
| 1.1.11 | ЗДҮАХ – 1.2.4, МУХТЖҮЧ-2.1.7, ЗГҮАХ-2.3.8 | “Боловсрол сан” байгуулж, хэрэгжүүлэх | 500.0 | | Сангийн журам боловсруулсан | Сан байгуулж, үйл ажиллагаа эхэслэн байна | Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" мөрийн хөтөлбөрөөс хасагдсан заалт. | 0 |
| 1.1.12 | ЗДҮАХ – 1.2.5, ЗГҮАХ-2.3.9, МУХТЖҮЧ-2.1.8 | ХБХ-ийн хөгжлийг дэмжсэн сургалтын орчныг нэмэгдүүлэх ЕБС-ийн “Хүүхдийн хөгжлийг дэмжих төв” | 20.0 | - | 1 кабинет байгуулсан | 5 кабинет байгуулна | 2023-2024 оны хичээлийн жилд нийт 20 ЕБС, МСҮТ-н дотуур байранд хүүхэд хөгжлийн өрөөг тохижуулж, "Дотуур байр, хүүхэд хөгжлийн өрөө" 10 сая төгрөгийн төсөвт уралдааныг зохион байгуулж, Тэшиг, Рашаант сургуулийн дотуур байр шалгарсан амжилтыг гаргасан. БЕГ, Булган, Орхон аймгийн БШУГ сургагч багш мэргэжилтнүүдийн хамтарсан "Дотуур байрны хүүхэд хамгаалал" дотуур байрын багш нарын сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 39 багш хамрагдсан. | 30 |
| 1.1.13 | ЗДҮАХ-1.2.1, ЗГҮАХ-2.3.15, МУХТЖҮЧ-2.1.5 | Манлайлагч сурагч, оюутанд 100 хувь хүртэл “Аймгийн Засаг даргын нэрэмжит сургалтын төлбөрийн тэтгэлэг” олгох | 250.0 | 496.0 | 35 сурагч хамрагдсан | 30 сурагч, оюутанд тэтгэлэг олгосон байна | Аймгийн Засаг даргын санаачилгаар хүүхэд бүрийн сурах хүсэл эрмэлзлэлийг хөгжүүлэх, сурлагын чанарыг ахиулах, багш нарын ур чадварыг сайжруулах зорилгоор тэтгэлэгт хөтөлбөрийг 3 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэн 2021 онд 30 оюутанд 140 сая төгрөгийн тэтгэлэг, 2022 онд 35 оюутанд 147 сая төгрөгийн тэтгэлэг 20 оюутанд 76 сая төгрөгийн дэмжлэг, 2023 онд 45 хүүхдэд 161 сая төгрөгийн тэтгэлэг, 36 хүүхдэд 97,3 сая төгрөгийн дэмжлэг урамшуулал олгоод байна. Мөн БНСУ-ын Кёнги аймгийн Шинхан их сургуульд орон нутагт нэн шаардлагатай тэргүүлэх чиглэлээр 20 оюутныг 100 хувийн тэтгэлгээр 4 жил, ОХУ-ын Буриад Улсын Хөдөө аж ахуйн их сургуульд 8 оюутныг 4 жил, Беларус улсад 3 оюутныг 4 жил тус тус 100 хувийн тэтгэлгээр суралцуулж байна. | 100 |
| **Зорилт 1.2. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнтэй тогтолцоог бэхжүүлнэ.** | | | | | | | | |
| 1.2.1 | МУХТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-2.1.3, ЗДҮАХ-1.1.1 | Орхон сумын ЭМТ барилгыг дуусгах | 2,168.6 | 2,168.6 | Ажлын явц 30 хувь | ЭМТ барилгыг ашиглалтад оруулсан байна | Орхон сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажил 2023 оны 9 сарын байдлаар барилгын карказ, гадна цахилгаан, барилгын өрлөг шавардлага хийгдэж дотор заслын ажил эхэлсэн байна. | 85 |
| 1.2.2 | МУХТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ-2.1.1, ЗДҮАХ-1.1.7 | Нөхөн үржихүйн насны болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслээр хангах | 50.0 | 300.5 | 79% | 81.4%-д хүргэнэ | Бүрэгхангай сумын эрүүл мэндийн төвд эмэгтэйчүүдийн үзлэгийн ор, бүрэн автомат төрөх ор тус бүр 1 ширхэгийг орон нутгийн төсвийн 19.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар авсан. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 300.5 сая төгрөгийн хандив тусламжаар эх, хүүхдийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай ЭХО аппарат, датчик, эхоны өнгөт принтер, инкубатор, автомат мэс заслын угаалтуур, мэс заслын гэрэл, нярайн НР, ургийн монитор, коагуляцийн аппарат, үзлэгийн ор, нярайн судас тодруулагч, яаралтай тусламжийн тэргэнцэр, нярайн ларингоскопоор хангагдсанаар эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэж байна. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.3 | ЗГҮАХ-2.1.1, МУХТЖҮЧ-2.2.1, ЗДҮАХ-1.1.3 | Хүн амын дунд эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулах | - | 36.2 | Эрт илрүүлэг үз55лэгийн хамралт 7%-тай байна | Эрт илрүүлэх үзлэгийн хамралтын түвшин 30 хувьд хүрсэн байна | "Хүрч үйлчилье" арга хэмжээний хүрээнд 10 суманд аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг зохион байгуулж, 12888 иргэнийг хамруулаа. Үзлэг, оношилгоогоор элэг, умай, хөхний хавдрын сэжигтэй 9, хоол боловсруулах замын эмгэг 443, зүрх судасны өвчлөл 85, шээс бэлгийн тогтолцооны эмгэг 78, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөл 23 тохиолдлыг илрүүлэн, зөвлөгөө өгч харьяа сумын эмчийн хяналтад шилжүүлсэн. Яаралтай онош тодруулах, эмчлүүлэх шаардлагатай 53 хүнийг дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэв. Энэ үеэр эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээллийг иргэдэд хүргэж, 283 иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулан 27.1 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүллээ. Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх сургалт, мэдээллийг 4645 хүнд өгсөн. | 100 |
| 1.2.4 | МУХТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ-2.1.1 | Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | - | - | 55.9% | "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээний хэрэгжилт 60%-д хүрсэн байна | "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээний хүрээнд 2 зорилт дэвшүүлэн 8 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувьтай байна. 2023 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрэгтэйчүүдийн кабинетаар 710 гаруй эрчүүдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн. “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо”-нд 10289 эрэгтэй хамрагдсан байна. | 100 |
| 1.2.5 | | | - | - | 32.0% | "Харшлаас сэргийлэх" арга хэмжээний хэрэгжилт 40%-д хүрсэн байна | "Харшлаас сэргийлэх" арга хэмжээний хүрээнд 2 зорилтын хүрээнд 5 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилт 80 хувьтай байна. Уг арга хэмжээний хүрээнд: ногоон байгууламжид ашиглах ургамлын талаар заавар боловсруулж, ухуулга нөлөөллийн ажил 2 удаа зохион байгуулсан. Ургамлын харшлын улирлын үед ЭМЯ, НЭМҮТ-өөс боловсруулан гаргасан урьдчилан сэргийлэх, оношилгоо эмчилгээний зөвлөмжийг цахимаар иргэд олон нийтэд 2 удаа түгээсэн. Харшил өвчнөөр эмчийн хяналтад арьсны харшилтай 105, астматай 80 иргэнд эмийг жороор олгож, эмийн гаж нөлөө, эмийн харшлын талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаж байна. | 100 |
| 1.2.6 | | | - | - | 68.3% | "Элэг бүтэн Монгол" арга хэмжээг хэрэгжүүлж, Д вирустай иргэдийг эмчилгээнд хамруулах ажил 70%-д хүрсэн байна | "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний хүрээнд 15-аас дээш насны 28337 иргэнийг хамруулж, хамралт 63.3 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 8.2%-иар өссөн. Үзлэгээр хавдрын сэжигтэй 9 тохиолдлыг эрт илрүүлж, дээд шатлалын эмнэлэгт шилжүүлсэн. Элэгний В, С вирусийн илрүүлэг шинжилгээнд 1954 хүн хамруулснаас 230 буюу 11.7 хувьд вирус илэрсэн.<br>Жирэмсний хяналтад орсон 330 эхийг “В”, ”С” вирус, ДОХ, тэмбүүгийн шинжилгээнд хамруулснаас “В” вирустэй 6, “С” вирустэй 1 эх илэрсэн. 2023 онд В вирустэй 12 эхээс төрсөн 12 нярайд иммуноглобулиныг В вирусийн вакцины хамт хийсэн. Эрүүл мэндийн 65 ажилтны В гепатитын дархлаажуулалтын тогтоцыг тодорхойлон дархлалт тогтоц тогтоогүй 20 ажилтныг В гепатитын дархлаажуулалтад хамруулав. Шинээр С вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээнд 5 хүн хамрагдан вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдаж, “В” вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээнд 13 хүн хамрагдан 12 хүн нь эмчилгээнд шинээр орж, нарийн мэргэжлийн эмчийн хяналтад аймгийн хэмжээнд 248 хүн “В” вирусийн эмчилгээ хийлгэж байна. Мөн В вирусийн эсрэг дархлаажуулалтад 690 иргэнийг хамруулсан. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай байна. | 100 |
| 1.2.7 | | | - | - | 85.7% | "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээнйи хэрэгжилт 88.3%-д хүрсэн байна. | "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээний хүрээнд 3 зорилт, 11 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн. Нэрэмжит сарын аян, тэмдэглэлт өдрүүд, сургалт, сурталчилгааг танхим болон цахимаар 94 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 12240 иргэнийг хамруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн. Аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчин болон коронавирусын халдварыг 7 хоног тутам харуулдан тандалтын нэгжүүдээр, бусад халдварт өвчний тандалтыг эрт сэрэмжүүлэх хариу арга хэмжээний тогтолцоогоор тус тус дамжуулан тандалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. Сүрьеэ өвчнийг илрүүлэх үзлэгт 575, БЗДХ-аас сэргийлэх эрт илрүүлэх үзлэгт 1056 хүнийг хамруулж, илэрсэн өвчлөлийг хавьтлын хамт эмчлэн эрүүлжүүлсэн. Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэхэд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж, дадлагажуулах, тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэх чадвар эзэмшүүлэх чиглэлээр 2 удаагийн танхимын, 6 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, нийт 180 гаруй эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Мөн хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын 3 сарын нөөцийг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд заавал хийх дархлаажуулалтын хамралт 93.6 хувьтай байна. Аймгийн төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.8 | | | - | - | 65.0% | "Хавдрын эсрэг" арга хэмжээний хэрэгжилт 70%-д хүрсэн байна | "Хавдрын эсрэг" арга хэмжээний хүрээнд 2 зорилт, 5 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилт 80 хувьтай байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалыг баримтлан эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд нийт үзлэгт хамрагдвал зохих 59553 иргэдээс 20624 буюу 34.6%-ийг хамруулаад байна. Үзлэгт хамрагдагсдыг насны ангиллаар нь авч үзвэл: 0-5 насны хүүхэд 72.2 хувь, 6-17 насны хүүхэд 74.2 хувь, 18-30 насны залуучуудын 14.3 хувь, 31-45 насны хүн амын 17.5 хувь, 46-60 насны 19.6 хувь, 61-ээс дээш насны 15.1 хувийг хамруулсан байна. Аймгийн Засаг даргын баталсан удирдамжаар "Хүрч үйлчилье" аяны хүрээнд нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг нийгмийн салбарын байгууллагуудтай хамтран Бүрэгхангай, Орхон, Сайхан, Баян-Агт, Хангал, Хялганат, Хутаг-Өндөр, Тэшиг зэрэг 8 сумандзохион байгуулж, давхардсан тоогоор 12240 иргэнийг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулсан. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоонд 18-34 насны 454 иргэнийг хамруулсан. Үзлэг, оношилгоогоор элэг, умай, хөхний хавдрын сэжигтэй 9, хоол боловсруулах замын эмгэг 162, зүрх судасны өвчлөл 85, шээс бэлгийн тогтолцооны эмгэг 62, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөл 23 тохиолдлуудыг илрүүлэн, зөвлөгөө өгч харьяа сумын эмчийн хяналтад шилжүүлсэн. | 90 |
| 1.2.9 | ЗДҮАХ-1.1.1, ЗГҮАХ-2.1.12, МУХТЖҮЧ-2.2.3 | 50 ортой төрөх, эмэгтэйчүүдийн эмнэлэг, Бугат, Тэшиг сумын ЭМТ-ийн барилгад их засвар хийх | 2,188.8 | 172.0 | Зураг төсөв хийгдсэн | Бугат, Тэшиг сумын ЭМТ-ийн барилгад их засвар хийсэн байна | Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт орон нутгийн төсвийн 172.5 сая төгрөгөөр их засварыг хийж гүйцэтгэж байна. Ажлын явц 90 хувьтай. Мөн Бугат, Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засварын зураг төсөв хийгдсэн. | 50 |
| 1.2.10 | ЗДҮАХ-1.1.1, ЗГҮАХ-2.1.12 МУХТЖҮЧ-2.2.3 | Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах | 826.1 | 439.1 | Тоног төхөөрөмжийн хангалт 87 хувь | 89 хувьд хүрсэн байна | Эрүүл мэндийн салбар нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар 439.1 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжөөр хангагдаж, аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн стандарт хангалт өмнөх оноос 0.2 пунктээр нэмэгдэж 89.7 хувьд хүрсэн байна. Үүнд: Аймгийн Нэгдсэн эмнэлэг эх, хүүхдийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай ЭХО аппарат, датчик, эхоны өнгөт принтер, инкубатор, автомат мэс заслын угаалтуур, мэс заслын гэрэл, нярайн НР, ургийн монитор, коагуляцийн аппарат, үзлэгийн ор, нярайн судас тодруулагч, яаралтай тусламжийн тэргэнцэр, нярайн ларингоскоп, эм тарианы шкаф зэрэг 300.5 сая төгрөгийн, анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд 24 нэр төрлийн 138.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр тус тус хангагдсан. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт 8, мэс заслын тасагт 10, амбулаторид 3, нийт 21 байршлыг камержуулан аюулгүй байдлыг сайжруулав. | 100 |
| 1.2.11 | ЗДҮАХ-1.1.2, МУХТЖҮЧ-2.2.8, ЗГҮАХ-2.1.9 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллахад орон байрны дэмжлэг үзүүлэх | 120.0 | 281.0 | Бүрэгхангай сумын эрүүл мэндийн төв 1 орон байрыг бэлтгэсэн | 2 суманд сууц барина | Хутаг-Өндөр сумын эрүүл мэндийн төвийн 1 их эмчид шинээр байшин барихад орон нутгаас 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, тус суманд шилжин ирж ажиллаж байгаа 1 их эмчийг түрээсийн байраар хангасан. Бугат сумын эрүүл мэндийн төв өөрсдийн нөөц бололцоогоор 2 эмнэлгийн мэргэжилтнийг амьдрах байраар хангаж, Тэшиг сумын эрүүл мэндийн төв 1 сувилагчийг орон сууцжуулах төсөлд хамруулан, түлээ модны дэмжлэг үзүүлсэн байна. Сэлэнгэ сумын эрүүл мэндийн төвийн 1 лаборантад орон нутгаас 1 өрөө байшин олгож, амьдрах орчныг тохижуулан өгсөн. Сайхан суманд эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зориулсан орон сууцыг барих зураг төсөл батлагдаж, орон нутгийн төсвөөс 280.0 сая төгрөг шийдвэрлээд байна. | 100 |
| 1.2.12 | ЗДҮАХ-1.1.8, МУХТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ-2.1.14 | Нүхэн 00-той эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох | 140.0 | - | Баяннуур, Гурванбулаг, Сайхан сумын эрүүл мэндийн төв ариун цэврийн байгууламжийг шинэчилсэн | Дашинчилэн, Орхон суманд стандарт хангасан ариун цэврийн байгууламжтай болгоно | Дашинчилэн сумын ЭМТ-ийн барилгад ЭМЯ-ны төслийн хөрөнгө оруулалтаар 15 ортой эрүүл мэндийн төвийн барилгыг 2023-2024 онд барихаар зураг төслийн "Хатанбаатар" ХХК гүйцэтгэж тухай зураг төсөль ариун цэврийн байгууламжийг бие даасан байдлаар зураг төсөвт тусгагсан. Эрүүл мэндийн яаманд гүйцэтгэгчийг шалгаруулах тендер зарласан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орхон сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажил хийгдэж байгаа бөгөөд тус ажилд ариун цэврийн байгууламжийг бие даасан байдлаар шийдсэн бөгөөд энэ ондоо багтаж ашиглалтад оруулна. | 50 |
| **Зорилт 1.3. Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, үндэсний өв уламжлалыг залгамжлан, орчин үеийн соёл урлагийн чиг хандлагыг** | | | | | | | | |
| 1.3.1 | МУХТЖҮЧ- 1.2.1 ЗГҮАХ- 2.6.2 ЗДҮАХ-1.4.2 | Соёлын төвийн барилга, 240 суудал /Бугат сум/ | 200.0 | 200.0 | Барилгын явц 70 хувьтай | Бүрэн ашиглалтад оруулна | Бугат сумын Соёлын төвийн шинэ барилгын барилга угсралтын ажлын 2023 онд хийгдэх УТ-200.0 сая төгрөгийн барилгын ажил бүрэн хийгдсэн. | 75 |
| 1.3.2 | МУХТЖҮЧ- 1.2.1 ЗГҮАХ- 2.6.2 ЗДҮАХ-1.4.2 | Соёлын төвийн засвар /Баяннуур сум/ | 224.7 | 219.3 | Барилгын явц 50 хувьтай | Барилгын их засвар бүрэн хийгдэж дууссан байна | Баяннуур сумын Соёлын төвийн барилгын их засварын /ОНТ-219.3 сая төгрөг/ ажлыг "Густокек" ХХК хийж ашиглалтад бүрэн хүлээн авсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.3 | МУХТЖҮЧ- 1.2.1 ЗГҮАХ- 2.6.2 ЗДҮАХ-1.4.2 | Соёлын төвийн засвар /Сэлэнгэ сум/ | 200.0 | 200.0 | Барилгын явц 70 хувьтай | Барилгын их засвар бүрэн хийгдэж дууссан байна | Сэлэнгэ сумын Соёлын төвийн барилгын их засварын ажил /2023 онд ОНТ-200,0 сая төгрөг/ "Хурмастын хүлэг" ХХК хийж ашиглалтад хүлээлгэн өгсөн. | 100 |
| 1.3.4 | МУХТЖҮЧ- 1.2.1 ЗГҮАХ- 2.6.2, ЗДҮАХ-1.4.2 | Соёлын ордны их засвар хийх /240 суудал/ | 250.0 | 375.0 | Зураг төсөв хийгдсэн | Булган болон Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн барилгын их засвар хийсэн байна | Булган сумын Соёлын ордны барилгын их засвар /ОНТ-150,0 сая төгрөг/-ын ажлын гүйцэтгэгч шалгаруулах тендер зарлагдаж гүйцэтгэгчээр "Хөх сэрхийн мандал" ХХК шалгарсан. Хутаг-Өндөр сумын Соёлын төв /ОНТ-225,0 сая төгрөг/-ийн засварын ажлын гүйцэтгэгчээр "Хурмастын хүлэг" ХХК шалгарч засварын ажил бүрэн хийгдэж дууссан. | 70 |
| 1.3.5 | МУХТЖҮЧ- 1.2.1 ЗГҮАХ- 2.6.1, ЗДҮАХ-1.4.2 | Аймгийн музейг камержуулах | 20.0 | 41.9 | Өмнө суурилагдсан камер ашиглалтын хугацаа дууссан | Музейг камержуулсан байна | Аймгийн музей /УТ-32,0 сая төгрөг/, Баруун замын байлдааны штаб музейд /9,9 сая төгрөг/ иж бүрэн камер, хөдөлгөөн мэдрэгч, ус чийг мэдрэгч, шил хагаралтын мэдрэгч, дулаан мэдрэгч, утаа мэдрэгч, дохиолол хамгаалалтын системийн нийт 41.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг "Бодь-Электроникс" ХХК суурилуулж хүлээлгэн өгсөн. | 100 |
| 1.3.6 | МУХТЖҮЧ- 1.2.1 ЗГҮАХ- 2.6.3, ЗДҮАХ-1.4.1 | "Булган нутгийн бахархал" контент бэлтгэх | 25.0 | 73.2 | Жил бүр 3 контент бэлтгэн гаргадаг | "Монгол-330" контент бэлтгэнэ | Монголын Үндэсний Олон нийтийн телевизийн "Монгол Өв" соёл нэвтрүүлгийн редакцитай хамтран Орхон, Булган, Хутаг-Өндөр сумын онцлог, соёлыг харуулсан нэвтрүүлэг бэлтгэсэн. Тус нэвтрүүлэгт Булган сумын иргэн өвлөн уламжлагч, Д.Дарьсүрэн "Уламжлалт сүүн будгийн технологи" өвлөн уламжлагч С.Зоригтбаатар, Д.Мөнх-Эрдэнэ, Х.Мөнхбаатар нар "Уламжлалт дархны ухаан" Орхон сумын иргэн Б.Батчулуун "Нүүдэлчдийн Монгол ахуй" Хутаг-Өндөр сумын иргэн Д.Жаргалсайхан "Нутгийн онцлог, өв"-ийн талаар мэдээлэл хүргэж оролцсон. Мөн соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн онцлог, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг таниулах зорилгоор Хөгнө хан уул, Элсэн тасархай, Их бага хийдийн туурь, Хадат хошуу зэрэг газруудаар аяллын маршрут гаргаж хүүхдийн танин мэдэхүйн "Том ахын аялал" нэвтрүүлэг бэлтгэн тус нэвтрүүлэгт Рашаант, Булган сумын ЕБС-ийн 15 сурагч оролцлоо. "Монголын баялаг-330" төсөл хөтөлбөрийн хүрээнд Булган аймгийн Байгалийн үзэсгэлэнт болон түүхэн дурсгалт газрууд, Соёлын биет болон Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах архивлах ажлын гэрээг "Монголын баялаг, өв соёл" ХХК-тай орон нутгийн төсвийн 73.2 сая төгрөгөөр байгуулсан. Тус ажлын хүрээнд 16 сумын нутаг дэвсгэрт орших улсын болон аймгийн хамгаалалтад байгаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл мэдээллийн санг дүрсжүүлэн баримтжуулж байна. | 100 |
| **Зорилт 1.4. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, амьдралын салшгүй хэсэг болгож, үндэсний болон өвөл, зуны спортуудыг дэмжиж, Булган аймгийн баг, тамирчдын өрсөлдөх чадвар,** | | | | | | | | |
| 1.4.1 | МУХТЖҮЧ-1.2.4, ЗГҮАХ-2.5.8, ЗДҮАХ-1.3.3 | Алхалт болон дугуйн зам, сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөгийн талбай байгуулах | 500.0 | 1,515.7 | Зориулалтын талбай байхгүй | Бүтээн байгуулалтын ажил эхэлсэн байна | Орон нутгийн төсвийн 520.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Алист констракшн" ХХК-тай гэрээ байгуулан Булган суманд явган болон дугуйн замыг барьж байна. МСҮТөвийн хажууд нийтийн биеийн тамирын талбайг ОНТ хөрөнгөөр тохижуулан ашиглалтад оруулаад байна. Бунхан толгой хүртэл Эрүүл мэндийн зам тавих ажлыг "Мөэжийн хишиг" ХХК гүйцэтгэж байна. | 90 |
| 1.4.2 | ЗДҮАХ-1.3.1 | БТСГ-ын Б заалны их засвар хийх | 250.0 | - | Стандарт шаардлага хангахгүй | Их засварыг хийж дууссан байна | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 250.0 сая төгрөг тусган гүйцэтгэгчийг шалгаруулах тендер зарласан. | 50 |
| **Зорилго 1.5. Хүн амын хөдөлмөр эрхлэлт, орон нутгийн онцлогт тохирсон гарааны бизнесийг дэмжин, шинээр бий болгосон ажлын байрыг тогтвортой хадгалж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 1.5.1 | МУХТЖҮЧ-2.6.2, ЗГҮАХ-2.5.4, ЗДҮАХ-1.5.1 | Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааны ном хэвлүүлэх | 10.0 | 10.0 | Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн нарийвчилсан судалгаа хийгдсэн | Ном хэвлэгдсэн байна | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг 2024 нэгжээс судалгаа авахаас 1885 нэгжээс авч гүйцэтгэл 93.1 хувьтай байна. Тус судалгааны урьдчилсан дүнгээр аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин 6.4 хувь буюу буурсан үзүүлэлттэй байна. Хөдөлмөрийн зах, зээлийн судалгааны эмхэтгэлийг нэгтгэн 3 дугаар улирал гаргахаар төлөвлөн ажиллаж байна. | 30 |
| 1.5.2 | МУХТЖҮЧ-2.6.2, ЗГҮАХ-2.5.4, ЗДҮАХ-1.5.2 | Их дээд сургууль болон МСҮТ-ийг төгссөн шинэ залуу боловсон хүчний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин төсөл хөтөлбөрт хамруулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх | 20.0 | 20.0 | 2017-2021 онд ХЭДС-аас 20 залуучуудын бүлэгт 200 сая төгрөг санхүүжилт олгосон | 2 бүлэгт санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна | Старт ап арга хэмжээг 8-р сарын 25-27 өдрүүдэд зохион байгуулж, сургалтанд 15 багийн 38-н залуучууд хамрагдан бизнес санаагаа өрсөлдүүлснээс Сайхан сумаас оролцогч Б.Бямбажавын /айраг савлах, худалдаалах/ "ОХЬ" брэнд, Дашинчилэн сумаас оролцогч Э.Дондог /модон эдлэл үйлдвэрлэх/ "Түмэнд түгээ багц", Булган сумаас оролцогч О.Лувсанжамц Булганы брэнд бүтээгдэхүүнийг савлах, худалдаалах Булганы брэнд санаанууд шалгарч хурдасгуур арга хэмжээнд хамрагдаж байна. Эцсийн сонгон шалгаруулалтыг 10-р сарын 5-нд зохион байгуулна. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5.3 | МУХТЖҮЧ-2.3.4, ЗГҮАХ-2.5.9, ЗДҮАХ-1.5.2 | МСҮТ-үүдэд "Мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж, багш нарыг давтан сургах, мэргэшүүлэх, гадаад дотоодын сургуульд суралцах, туршлага судлуулах | 45.0 | - | - | Шаардлагатай мэргэжилтэй ажилчдыг бэлтгэн, багш нарын 80-аас доошгүй хувийг хамруулж, сургалтын чанарт ахиц гарсан байна | ОХУ-ын Эрхүү мужийн Байкальскийн үйлдвэрлэл үйлчилгээний техникум, Эрхүүгийн авто тээвэр, замын барилгын коллеж, Барилга архитектурын техникум түүний Шелехов хотын салбар сургуультай барилгын засал чимэглэлийн чиглэлээр мэргэжлийн 1 багш, гагнуурчны мэргэжлийн 1 багш, гагнуурчны мэргэжлийн курсийн 1 оюутан, Японы OISCA олон улсын байгууллагатай байгуулсан санамж бичгийн хүрээнд органик тариалалтын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад 1 багш, нийт 4 хүнийг гадаадад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах сургалтуудад 21 хоногоос 10 сар хүртэлх хугацаанд хамруулалаа. Хангайн бүсийн болон Завхан аймгийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын оёдлын мэргэжлийн багш суралцагчдын “Ур чадвар-2023" уралдаанд оёмол бүтээгдэхүүн оёдолчин мэргэжлийн ангийн 2 багш оролцон тусгай байр эзэлж, 3 багш туршлага солилцох сургалтад, Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан 8 аймгийн "Хангайн бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах 2023" ур чадварын тэмцээнд тогоочийн мэргэжлийн ангийн 2 багш, 1 оюутан оролцон тусгай байр эзэлж, 2 багш туршлага судлах сургалтад, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын багш, суралцагчдын дунд зохиогдсон "Эх хэл бидний бахархал" монгол хэлний улсын XVII олимпиадад 2 багш, 1 оюутан оролцож, 5 дугаар байр эзэлсэн амжилт үзүүлж, нийт 11 багш 2 оюутан туршлага судлах сургалт, ур чадварын тэмцээнд оролцлоо. | 100 |
| 1.5.4 | МУХТЖҮЧ-2.6.2, ЗГҮАХ-2.5.9, ЗДҮАХ-1.5.3 | Ажилгүй болон ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажилд зуучлан жил бүр 1300-аас доошгүй ажлын байрыг бий болгох | - | - | Байнгын болон түр 1608 ажлын байранд зуучлан ажилласан | 1300-аас дээш ажлын байрыг бий болгоно | 2023 оны эхний 9 сарын байдлаар ажил олгогч 324 байгууллагаас давхардсан тоогоор 766 ажлын байрны захиалга авч мэдээллийг "Сайхан Монгол" телевиз болон зарын цэгүүд, цахим хуудсанд байршуулан 916 иргэнийг ажилд зуучилснаас байнгын ажлын байранд 377, улирлын ажлын байранд 113, түр ажлын байранд 426 иргэн зуучлагдсан. Энэ оны эхний хагас жилийн байдлаар төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шинээр 928 ажлын байр бий болсноос 243 байнгын ажлын байр, 153 улирлын ажлын байр, 532 түр ажлын байр тус тус бий болсон байна. | 70 |
| **Зорилго 1.6. Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх халамж хамгааллын үйлчилгээг гэр бүлд төвлөрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны болон хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах, хүйсийн** | | | | | | | | |
| 1.6.1 | МУХТЖҮЧ-1.2.4, ЗГҮАХ-2.5.8, ЗДҮАХ-1.6.2 | Хүүхдийн Жаргалант зуслангийн барилгын ажил хийж дуусгах | 313.9 | 551.6 | Ажлын явц 95% | Захиргаа аж ахуй, гал тогооны барилгын ажлыг дууссан байна | Жаргалант зуслангийн хоол, сургалтын танхим бүхий захиргаа удирдлагын байрны барилгын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Эко эрдэнэс үүр" ХХК гүйцэтгэн, барилгын ажил 85.0 хувьтай байна. Барилгын үлдэгдэл санхүүжилтийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээнд 307.6 сая төг, ОНТ 244.0 сая төгрөг тусган Захиргаа аж ахуй, гал тогооны барилгын ажлыг энэ онд багтаан дуусгахаар ажиллаж байна. Мөн зуслангийн үргэлжлэл ажил болох 60 хүүхдийн "Жаргалант" хотхоны барилгын ажлын саналыг 2024 оны улсын төсөвт тусгуулахаар холбогдох байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд зуслангийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 4 хотхон, ерөнхий дэд бүтэц, орчны тохижилтын зураг төсвийг мэргэжлийн байгууллагуудаар хийж гүйцэтгүүлж байна. | 90 |
| 1.6.2 | МУХТЖҮЧ-7.3.6 ЗГҮАХ-4.3.3 ЗДҮАХ-1.6.2 | ГБХЗХГ-ын дэргэдэх гэр бүлийн хүчирхийллээс “Түр хамгаалах” байрны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 50.0 | 48.0 | 187 м.кв талбай бүхий байр бөгөөд 2 төслийн гүйцэтгэл 80 орчим хувьтай байна | Бүрэн ашиглалтад оруулж, тоног төхөөрөмжөөр хангасан байна | Австрали улсын элчин сайдын яамны бичил төслийн дэмжлэгээр барьж, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 48.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сангийн холболт хийгдсэн түр хамгаалах байрны барилгын явц 100 хувьтай байна. | 70 |
| 1.6.3 | МУХТЖҮЧ-1.2.4, ЗГҮАХ-2.3.5, ЗДҮАХ-1.6.2 | ХХҮГ-ын харьяа ахмадын амралтын газрын барилгын их засвар хийх, тоног төхөөрөмжөөр хангах | 481.9 | 249.8 | Зураг төсөвтэй | Засварын ажил хийгдсэн байна | Орон нутгийн төсвийн 249.8 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар их засварын ажлыг гүйцэтгэхээр "Хурмастын хүлэг" ХХК шалгарч, барилгын их засварыг хийж байна. | 50 |
| **БҮЛЭГ2.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| **Зорилт 2.1. Эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.** | | | | | | | | |
| 2.1.1 | МУХТЖҮЧ- 8.3.1, ЗГҮАХ-3.3.3 | Тэшиг суманд цөцгийн тос үйлдвэрлэх сүүний ферм байгуулах | 2,700.0 | 2,680.0 | Ферм байгуулах ажил эхэлсэн | Сүүний ферм ашиглалтад орсон байна | Тэшиг суманд 250 толгой үхрийн ферм, хоногт 6 тн сүү боловсруулах хүчин чадалтай цөцгийн тосны үйлдвэр байгуулахаар улсын төсвийн 2.68 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж, барилгын цутгалтын ажил дууссан дүүргэлтийн ажил хийгдэж байна. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2 | МУХТЖҮЧ- 8.3.1, ЗГҮАХ-3.3.3, ЗДҮАХ-2.3.5 | Орон нутагт сүүний үйлдвэрийн кластерийг хөгжүүлэх бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлж, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хангамжийг нэмэгдүүлэх | - | - | Өдөрт 10 тонн хүртэл сүү боловсруулах хүчин чадалтай болсон | Үйлдвэрийн аргаар 350 тн сүү боловсруулсан байна | Булган сумын "Хатан мээж хайрхан" ХХК 349 тонн сүүг урамшууллын хугацаанд авч, 1 л тутамд 450 төгрөгийн урамшуулалд хамруулав. 33 тонн аарц, 10 тонн цөцгийн тос, ааруул үйлдвэрлэн Улаанбаатар хот, Эрдэнэт, Булган аймгийн зах зээлд нийлүүлж байна. Тус үйлдвэр сүү боловсруулах технологийн явцад гарсан шар сүүг Зүүн хараагийн спирт бал бурмын үйлдвэрт нийлүүлэхээр хэлэлцээр хийж, үйлдвэрийн байранд өргөтгөл засварын ажлыг хийлээ. Булган сумын "Эко хүнс" ХХК-ийн "Чихэртэй ааруул", "Чихэргүй ааруул" нэрийн бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулан баталгаажуулж, зах зээлд нийлүүлж байна. | 100 |
| 2.1.3 | МУХТЖҮЧ- 8.3.1, ЗГҮАХ-3.3.3, ЗДҮАХ-2.3.5 | Хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хямд үнэтэй мах нөөцөлж, нийлүүлэх арга хэмжээг зохион байгуулах | 50.0 | 25.0 | 61.5 тонн | 25 тонноос багагүй мах нөөцөлнө | Орон нутгийн төсвөөс 2023 оны хаврын улиралд нөөцийн мах бэлтгэн нийлүүлэх урамшуулалд 25.0 сая төгрөг шийдвэрлэж, Булган сумын хүн амын хүнсний хэрэгцээнд хямд үнэтэй мах нийлүүлэх ажлыг зохион байгууллаа. "Мал, мах бэлтгэх, махны нөөц бүрдүүлэх, түүнийг хадгалах, худалдан борлуулахад хяналт тавих" гэрээг Булган сумын "Өнө мөнх бадрах" ХХК-тай байгуулж, гэрээний хүрээнд 1 кг үхрийн махыг 10600, хонины махыг 8600 төгрөгөөр борлуулж, кг тутамд 2500 төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэж, 9746.28 кг мах нийлүүлэв. Үүнээс үхрийн мах 3061.11 кг, хонины мах 6685.17 кг-ийг тус тус нийлүүлсэн байна. | 50 |
| 2.1.4 | МУХТЖҮЧ- 8.3.1, ЗГҮАХ-3.3.3, ЗДҮАХ-2.3.5 | Ахуйн үйлчилгээний барилгын засвар | 100.0 | 725.0 | 200 сая төгрөгийн санхүүжилтийг хийсэн | Ахуйн үйлчилгээний барилгын засварыг 80 хувьд хүргэнэ | "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газар, Булган аймгийн хамтын ажиллагааны хүрээнд 299.8 сая төгрөгөөр оёдлын үйлдвэрийн байр авч, 40.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн дэмжлэг үзүүлэн "Зэндмэнэ Уул" ХХК үйлдвэрийн байрны засварыг 59.5 сая төгрөгөөр гүйцэтгэж байна. Тус үйлдвэр нь орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан соёл, спортын салбарын захиалгат хувцсыг үйлдвэрлэж байна.<br>2023 онд Гурванбулаг сумын ахуйн үйлчилгээний их засварын үргэлжлэх ажилд орон нутгийн төсвөөс 200.0 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 200.0 сая төг хөрөнгө оруулалт шийдвэрлэж, Хурмастын хүлэг ХХК-тай байгуулаад байна. Баян-Агт сумын халуун усны барилгын ажил үргэлжилж, Бүрэгхангай сум орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр халуун ус барих ажлыг эхлүүлж, Тэшиг сум урсгал засвар хийж байна. Рашаант сум орон нутгийн хөгжлийн сангаас 5.0 сая төгрөгөөр ахуйн үйлчилгээний төвд урсгал засвар хийж, Хялганат тосгон хоршоо хөгжүүлэх сангаас халуун усны үйлчилгээг хөгжүүлэх төсөлд 15.0 сая төгрөг,ЖДҮДСангаас Гурванбулаг сумын ахуйн үйлчилгээ эрхлэх 1 төсөл 70.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. Булган сумын 6 дугаар баг Чин ван Ханддоржийн өргөн чөлөө 1-р гудамж 109а тоотод Бизнес хөгжлийн төв буюу ахуйн үйлчилгээний төв барих 654 м.кв газрыг шийдвэрлэж, зураг төсвийг "Аслаан" ХХК 40.5 сая төгрөгөөр гүйцэтгэж байна. | 70 |
| **Зорилт 2.2. Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвар бүхий тогтвортой үйлдвэрлэлтэй, эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.** | | | | | | | | |
| 2.2.1 | ЗДҮАХ-2.2.3, ЗГҮАХ-3.3.12 | "Шинэ хөдөө" төсөл | 2,818.0 | 3,165.0 | - | "Шинэ хөдөө" төслийг үргэлжлүүлнэ | Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" (Булган) төсөл, арга хэмжээний 2022-2023 оны хөрөнгө оруулалтуудыг ХХААХҮЯамнаас худалдан авах ажиллагааг зохион байгуулж, энэ оны 08 дугаар сарын 31-нд аймаг орон нутагт нийлүүлэгдэж дууссан. Тус хөрөнгө оруулалтаар дундын техник 11 ширхэг, бог мал 608 толгой, нийлэг хальсан хүлэмж 25, 140 бүл зөгий нийлүүлэгдэж, орон нутгийн өмчид бүртгэж аваад байна. Эдгээр хөрөнгө оруулалтыг аймгийн ИТХ-ын XVIII Хуралдааны шийдвэрээр "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн данс бүртгэлд тусгуулж, сумдад нийлүүлэхээр төлөвлөж байна. | 100 |
| 2.2.2 | МУХТЖҮЧ-8.3.5, ЗГҮАХ-3.3.8, ЗДҮАХ-2.2.6 | Малын гоц халдварт шүлхий, мялзан, үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг зохион байгуулах | 8.5 | 357.5 | Нийт өвчлөлийн 4 хувь | 1.6 хувиар бууруулна | Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны "Тандалтын төлөвлөгөө батлах тухай" тушаалын дагуу аймгийн хэмжээнд гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний вирусийн тархалтын цар хүрээ, халдварлалтын түвшин, вирусийн эргэлт, үр дүнг үнэлэх тандалтад 13 сумын 31 өрхийн 480 толгой малыг хамруулж, 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа. | 100 |
| 2.2.3 | МУХТЖҮЧ-8.3.5, ЗГҮАХ-3.3.8, ЗДҮАХ-2.2.6 | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг сайжруулж, өвчин гарах, тархах нөхцөлийг хязгаарлах | 1,159.0 | 607.0 | Нийт өвчлөлийн 2 хувь | 1.3 хувь хүртэл бууруулна | 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 12 нэр төрлийн халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд нийт 3433.7 мянган толгой мал, амьтан хамруулахаас 2714.2 мянган мал, амьтан хамруулж, гүйцэтгэл 80 хувьтай байна. Нийт өвчлөлийн бууралтын хэмжээний дүн мэдээ жилийн эцсээр гарна. | 80 |
| 2.2.4 | МУТЖҮЧ-4.1.4, ЗГҮАХ-3.3.8, ЗДҮАХ-2.2.8 | Тариалангийн талбайг агрохимийн шинжилгээнд бүрэн хамруулах | 500.0 | - | Тариалангийн талбайн 60 хувь хамрагдсан | 20.0 мянган га талбайг хамруулна | Хангал сумын 2 аж ахуйн нэгж 1951 га талбай, Тэшиг сумын 12 аж ахуйн нэгж, иргэн 6100 га талбай, Сэлэнгэ сум 1648 га талбай, нийт 9699 га талбайг агрохимийн шинжилгээнд хамруулаад байна. | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.5 | МУХТЖҮЧ-8.3.3, ЗГҮАХ-3.3.4, ЗДҮАХ-5.1.9 | Бэлчээрийн хортон мэргэчтэй тэмцэх | 64.0 | 64.0 | 40.0 мянган га | Урд бүсийн сумдад тэмцэх ажлыг хийсэн байна | Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч амьтантай энгийн механик, биологийн аргаар тэмцэх арга хэмжээг орон нутгийн төсвийн 64.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хаврын улиралд Сайхан, Рашаант, Дашинчилэн, Баяннуур, Гурванбулаг, Хангал сумын бэлчээрийн 40.0 мянган га талбайд, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар намрын улиралд Сайхан, Рашаант, Дашинчилэн, Баяннуур, Гурванбулаг сумдын 30.0 мянган га талбайд тэмцэх ажлыг зохион байгуулсан. | 100 |
| 2.2.6 | МУТЖҮЧ-4.2.2, ЗГҮАХ-3.3.8, ЗДҮАХ-2.2.5 | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх | 450.0 | 297.0 | 10 худаг гаргасан | 10 худаг гаргана | Байгаль хамгаалах сангийн 297.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Агт, Бугат, Гурванбулаг, Могод, Рашаант, Хутаг-Өндөр, Дашинчилэн, Булган, Орхон, Сэлэнгэ, Хишиг-Өндөр суманд нийт 11 худаг гаргаад байна. | 100 |
| **Гурав. НОГООН ХӨГЖИЛ** | | | | | | | | |
| **Зорилт 3.1. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, байгаль орчны тогтвортой байдлыг хангаж үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе** | | | | | | | | |
| 3.1.1 | МУХТЖҮЧ-6.2.5, ЗГҮАХ-5.1.5, ЗДҮАХ-3.1.2 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулалт | 348.4 | 136.8 | 130 га | 100 га | Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 100 га талбайд ойжуулалт хийхээр төлөвлөсөн. Тус ажлын тендер сонгон шалгаруулалтыг 3 багцад явуулж, 2, 3 дугаар багцын 75 га талбайд "Хөвөнтөн ой" ХХК шалгаран аймгийн Засаг даргатай 26/2023, 27/2023 дугаар гэрээ байгуулан, тарилтын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 10 дугаар сард насжилтийг тооцон хүлээн авна. Мөн 1 дүгээр багцын ойжуулалтын ажил 10 сард хийгдэнэ. | 75 |
| 3.1.2 | МУХТЖҮЧ-6.2.5, ЗГҮАХ-5.1.5, ЗДҮАХ-3.1.2 | Ойн хортон шавжааc урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг үе шаттай зохион байгуулах | 1,515.0 | 788.5 | 300000 га судалгаа хийсэн. 31950 га-д хортоны тэмцлийн ажил хийсэн | 500000 га талбайд судалгааны ажил, 50000 га талбайд хортон шавжтай тэмцэх ажил хийнэ | Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 500000 га талбайд ойн хортны судалгааны ажлыг зохион байгуулахаар 39.7 сая төгрөгөөр "Аглаг ой" ХХК гүйцэтгэгчээр шалгаран, гэрээ байгуулан ой бүхий 12 суманд ажиллаж байна. Ойн хортны тэмцлийн ажлын гүйцэтгэгчээр 1-р багцад “Гранд форест” ХХК 302.5 сая төгрөгөөр, 2-р багцад “Ойн таксаци” ХХК 298.0 сая төгрөгөөр, 3-р багцад “Мөнх ногоон ой” ХХК 148.29 сая төгрөгөөр шалгарч аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан, Баян-Агт, Бугат, Бүрэгхангай, Орхон, сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын 23932 га талбайд гүйцэтгэхээр төлөвлөснөөс 19000 га-д гүйцэтгээд байна. Мөн улсын төсвийн хөрөнгөөр оруулалтаар Сэлэнгэ, Сайхан суманд 7000 га талбайд хортонтой тэмцэх ажлыг хийж гүйцэтгэсэн. | 90 |
| 3.1.3 | МУХТЖҮЧ-6.2.1, ЗГҮАХ-5.1.5, ЗДҮАХ-5.1.9 | Цөлжилт элсний нүүдлийг тогтоон барих зорилгоор Рашаант, Дашинчилэн, Баяннуур, Хутаг-Өндөр суманд ойн зурвас байгуулах | 100.0 | 158.2 | 4 га | Баяннуур, Дашинчилэн 6 га талбайд элсний нүүдлээс хамгаалах зурвас байгуулна | Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд Баяннуур, Дашинчилэн сумын 4 га талбайд ойн зурвасын ажлын 1, 2 дугаар багцад “Хөвөнтөн Ой” ХХК шалгарч тарилтын ажлыг 100 хувь гүйцэтгэлээ. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Рашаант суманд элсний нүүлтээс сааруулах механик хаалт 8 га талбайд хийх ажлын гүйцэтгэгчээр "Есөн мөнх сүлд" ХХК 71.5 сая төгрөгөөр шалгарч хашаажуулах ажлыг бүрэн дуусгасан, сүрлээр механик хамгаалалт хийх ажил хийгдэж байна. 10 дугаар сард хүлээн авна. | 100 |
| **Зорилт 3.2. Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлнэ** | | | | | | | | |
| 3.2.1 | МУХТЖҮЧ-6.3.2, ЗГҮАХ-5.1.6, ЗДҮАХ-3.1.1 | Хөв цөөрөм байгуулах | 231.9 | - | Зураг төсвийг хийж гүйцэтгэсэн | Нэг хөв цөөрөм байгуулна | 2022 онд Дашинчилэн, Гурванбулаг суманд хөв цөөрөм хийх зураг төсвийн ажлыг 23.7 сая төгрөгөөр хийлгэсэн боловч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар тус санал хасагдсан. | 30 |
| 3.2.2 | МУХТЖҮЧ-6.3.1, ЗГҮАХ-5.1.6, ЗДҮАХ-3.1.1 | Булаг шандын эхийг хашиж хамгаалах | 123.8 | 68.0 | 10 булаг хашиж хамгаалсан | Бэлчээрийн усан хангамж сайжирсан байна | Баян-Агт сумын Туухайн булаг, Баяннуур сумын Борогчингийн булаг, Булган сумын Майдарын булаг, Бүрэгхангай сумын Баянхангайн зүүн булаг, Гурванбулаг сумын Үзүүр булаг, Дашинчилэн сумын Түргүүний эх, Могод сумын Бунханы булаг, Орхон сумын Ар булаг, Хишиг-Өндөр сумын Цагаан хашаатын эх зэрэг 9 газарт булаг шандын эхийг хашиж хамгаалах ажлыг "Есөнмөнх сүлд" ХХК хийж гүйцэтгэлээ. | 100 |
| 3.2.3 | МУХТЖҮЧ-6.3.4, ЗГҮАХ-5.1.6, ЗДҮАХ-3.1.1 | Усны сан бүхий газрын хамгаалатын бүсийг тэмдэгжүүлэлтийн ажлыг хийх | 49.0 | 49.0 | 200 тэмдэгжүүлэлт хийсэн | 200 тэмдэгжүүлэлт, усны тоо бүртгэлийн ажлыг хийнэ | Аймгийн хэмжээнд Хануй, Сэлэнгэ, Орхон-Чулуут голын сав газрын захиргаадтай хамтран Баян-Агт, Булган, Бугат, Орхон, Сайхан, Сэлэнгэ, Хангал, Хутаг-Өндөр сумдын усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын, эрүүл ахуйн бүсэд 160 ширхэг тэмдэгжүүлэлт суурилууллаа. | 80 |
| **ДӨРӨВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ** | | | | | | | | |
| **Зорилт 4.1. Хот байгуулалт, инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, орон сууцны шинэ хороолол байгуулж, иргэдийн аюулгүй, тав тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.** | | | | | | | | |
| 4.1.1 | МУХТЖҮЧ-8.1.10, 9.3.3, ЗГҮАХ-3.7.12, ЗДҮАХ-5.1.4 | Үерийн хамгаалалтын байгууламж /Хутаг-Өндөр сум/ | 3,605.0 | 1,677.1 | Ажлын явц 30 хувь | Байгууламжийг барьж дуусгана | Хутаг-Өндөр сумын төвийн үерийн хамгаалалтын далан сувгийн угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Хангилцаг" ХХК шалгаран 4279.5 сая төгрөгөөр гэрээ байгуулан 2022 онд ажлыг эхлүүлсэн.С-3, С-4 сувгийн ажил 100 хувь хийгдээд түр зогссон. 9 сарын 26-ны өдрөөс үлдсэн ус тосох байгууламж, ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байна, эдгээр ажлыг гүйцэтгэснээр ашиглалтад оруулах улсын комисс ажиллана. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.2 | МУХТЖҮЧ-8.1.10, 9.3.3, ЗГҮАХ-3.7.11, 6.2.7, ЗДҮАХ-5.1.5 | Сумын төвийн инженерийн хангамж, дэд бүтэц /Булган, Орхон, Хутаг-Өндөр, Сэлэнгэ сум/ | 1,402.1 | 1,344.2 | 70 хувь | Байгууламжийг барьж дуусгана | Эрч арвин ХХК шалгарч, Орхон сум 448.8 сая, Хутаг-Өндөр сум 424.8, Сэлэнгэ сум 626.2 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгэж улсын комисс хүлээн аваад байна. | 100 |
| 4.1.3 | МУХТЖҮЧ-4.2.7, ЗГҮАХ-3.5.1, ЗДҮАХ-5.1.8 | Тэшиг сумын төвийн 35 кв-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам | 6,600.0 | 1,781.1 | Гүйцэтгэгч шалгарсан | Тэшиг сумын төвийн 35 кв-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг ашиглалтад оруулна | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Тэшиг сумын Хонгор багт хийгдэж байна. 2023-2024 он дамнан хэрэгжинэ. | 90 |
| 4.1.4 | МУХТЖҮЧ-3.6.5, ЗДҮАХ-3.4.3 | Булган аймагт ашиглагдаж байгаа төсвийн байгууллагын барилга байгууламжийг паспортжуулах | 60.0 | 60.0 | - | Төсвийн байгууллагын барилга байгууламжийг паспортжуулсан байна | 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 60.0 сая төгрөг тусган Булган сумын төвд МСҮТ-ийн дадлагын байр, Сэлэнгэ сумын ЕБС-ийн даралтат цамхаг, аймгийн Нэгдсэн эмнэлгийн төв байр, Тэшиг сумын соёлын төвийн барилга, Хутаг-Өндөр сумын 320 хүүхдийн суудалтай хичээлийн байр, Гурванбулаг сумын ЕБС-ийн 80 ортой дотуур байрны барилга, Дашинчилэн сумын хүүхдийн цэцэрлэг, Орхон сумын соёлын төвийн барилга, Хялганат тосгоны Сэлэнгэ мөрний гүүр, Булган сумын 1-р сургуулийн 2 давхар дотуур байр зэргийг паспортжуулахаар гүйцэтгэгчийг шалгаруулах тендер зарлаад байна. | 30 |
| 4.1.5 | МУХТЖҮЧ-8.1.10, 9.3.4, ЗГҮАХ-6.2.7, ЗДҮАХ-3.4.2 | Рашаант сум, Хутаг-Өндөр сумын Унът баг, Хантай, Хонгор, Орхон сумын Халуин баг, Сэлэнгэ сумын Тариахтай, Атар, Тэшиг сумын Хужирт баг, Дондогийн булаг, Их булаг рашаан, Баян-Агт сумын Ханүйн рашааны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах | 420.5 | 140.0 | 15 сум, 1 тосгон ерөнхий төлөвлөгөө хийлгэсэн | Рашаант сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна | Бугат сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Эрхэт констракшн" ХХК гүйцэтгэж байгаа ба төлөвлөлтийн хил, суурь судалгааны ажил дуусаж, ерөнхий төлөвлөлтийн ажлыг гүйцэтгэж байна. Дашинчилэн сумын хэсэгчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Өрнөх гүнт" ХХК гүйцэтгэж төгсгөлийн тайланг нутгийн захиргааны байгууллагуудтай зөвшилцөж байна. Рашаант сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчийг сонгож, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Булган сумын 4-р багийн хэсэгчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Эрхэт констракшн" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд төлөвлөлтийн хил, суурь судалгаа болон ерөнхий төлөвлөлтийн ажил дуусаж, нутгийн захиргааны байгууллагуудтай зөвшилцөх ажил хийгдэж байна. Хутаг-Өндөр сумын Дондогийн булаг орчмын суурьшлын бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг зарлаад байна. | 70 |
| 4.1.6 | ЗДҮАХ-3.4.3 | Барилгын засвар, дулаалгын ажлын эрэмбийг тогтоож, ээлж дараатайгаар хэрэгжүүлэх | 350.0 | 350.0 | 12,14,15-р, 18а,б байрнуудын фасадны засварыг хийгдсэн | 10 барилга дулаална | Нийтийн эзэмшлийн орон сууцны фасадны засвар /Булган сум/ ажилд 11, 19, 32-р байрыг засварлахаар тусгагдсаны дагуу гүйцэтгэж комисс хүлээн авсан. | 100 |
| 4.1.7 | ЗГҮАХ-6.2.8, ЗДҮАХ-3.4.3 | Булган сумын төвд 35 айлын орон сууц барьж ашиглалтад оруулах | - | - | 2022 онд 28 айлын 1 блок орон сууц ашиглалтад орсон | 35 айлын орон сууц барьж ашиглалтад оруулсан байна | Сайхан суманд төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц барих гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлаа эхлүүлсэн. Хутаг-Өндөр сумын төрийн албан хаагчийн орон сууцны барилга, Хангал сумын Хялганат тосгонд төрийн албан хаагчийн 6 айлын орон сууц барих суурийн ажил дууссан, ханын өрлөгийн ажил явагдаж байна. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Булган суманд 5 байршилд 120 айлын орон сууц баригдаж байна. | 70 |
| 4.1.8 | ЗДҮАХ-3.4.1 | Баян-Агт, Булган, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр сумын газар зүйн нэрийн тодруулалт хийж, мэдээллийн сан үүсгэх | 444.3 | 408.9 | Баянуур, Бугат, Бүрэгхангай, Могод, Сайхан, Сэлэнгэ, Рашаант сумын газар зүйн мэдээллийн сан үүсгэгдсэн | 9 сумын газар зүйн нэрийн тодруулалт хийгдэж, мэдээллийн сантай болсон байна | Баян-Агт, Булган, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан үүсгэх ажлыг гүйцэтгэх нээлттэй тендерийг зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулаад байна. | 70 |
| 4.1.9 | МУХТЖҮЧ-4.2.7, ЗГҮАХ-3.5.1, ЗДҮАХ-5.1.8 | Эрчим хүчний эх үүсвэр, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх | 350.0 | 257.2 | Зураг төсөвтэй /2022/ | Баяннуур сумын төвийн цахилгаан хангамжийн 0.4 кв-ын ЦДАШ-ын шинэчлэл хийнэ | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 280.0 сая төгрөг тусган гүйцэтгэгчээр "Цац эрчис" ХХК шалгаран аймгийн Засаг даргатай 257.2 сая төгрөгөөр 2023 оны 09 дүгээр сарын 29 ашиглалтад оруулахаар гүйцэтгэж байна. | 70 |
| **Зорилго 4.2. Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг хөгжүүлж, авто замын чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | | |
| 4.2.1 | МУХТЖҮЧ-8.1.10, ЗГҮАХ-6.2.7, ЗДҮАХ-3.4.9 | Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.8км /Дашинчилэн сум/ | 1,340.0 | 1,995.5 | Гүйцэтгэгч шалгарсан | Дашинчилэн сумын авто замыг ашиглалтад оруулна | Дашинчилэн сумын 1.8 км авто замын ажлыг "Таван богд оферүд" ХХК улсын төсвийн 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр төлөвлөгөөт хуваарийн дагуу хийж дуусч байна. Улсын комисс 10 дугаар сард ажиллаж хүлээн авна. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.2 | МУХТЖҮЧ-8.1.10, 9.3.4, ЗГҮАХ-6.2.7, ЗДҮАХ-5.1.6 | Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж, ашиглалтад оруулах | 2,000.0 | 2,328.8 | Ажлын явц 30 хувь | Авто замыг барьж ашиглалтад оруулсан байна | Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замын ажил нийт 4 багц бөгөөд Хялганат доторх 10 км авто замыг "Увт инвэст"ХХК гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Хялганат тосгоны Сэлэнгэ голын гүүрнээс Хангал сумын гүүр хүртэлх 22.3 км авто замыг "Замын бетум" ХХК гүйцэтгэж, одоогоор далан гүүрний засварын ажлыг хийж байгаа бөгөөд авто замд хучилт хийх ажил явагдаж байна. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Сэлэнгэ" амралт болон "Олимп" амралт хүртэлх 10 км зам, мөн гүүр далангийн ажлыг "Жавхлант харгуй" ХХК, Хангал сумын гүүрнээс Орхон аймгийн 3 замын уулзвар хүртэлх 30 км авто замын ажлыг "Хурдны зам" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд эхлэлийн хучилт, далан гүүрний ажил хийгдэж байна. | 70 |
| 4.2.3 | МУХТЖҮЧ-8.1.10, ЗГҮАХ-6.2.7, ЗДҮАХ-3.4.9 | Сумын төвүүдийг ээлж дараатайгаар хатуу хучилттай авто замтай болгох | 3,200.0 | 1,767.9 | Булган сумын 4 р багийн замыг ашиглалтад оруулсан | 2-3 сумын төвийн авто замыг бетон хучилттай болгох ажлыг эхлүүлнэ | Орон нутгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар Орхон сумын төвийн хатуу хучилттай авто замд гүйцэтгэгчээр "Энх алтаргана" ХХК шалгарч 217.3 сая төгрөгийн өртөг бүхий замын ажил, Бугат сумын төвийн хатуу хучилттай авто замд гүйцэтгэгчээр "Энх алтаргана" ХХК шалгаран 218.2 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгэж комисст хүлээлгэн өгсөн. Рашаант сумын төвийн авто замд 100.0 сая төгрөг, Хишиг-Өндөр сумын төвийн авто замд 60.0 сая төгрөг төлөвлөгдөн гүйцэтгэж, комисс хүлээн авахаар ажиллаж байна. | 100 |
| **ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | |
| **Зорилт 5.1. Цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлнэ.** | | | | | | | | |
| 5.1.1 | МУХТЖҮЧ-5.3.2, ЗГҮАХ- 4.1.1, ЗДҮАХ-4.1.1 | Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх | 2.0 | - | - | 150 төрийн албан хаагчийг тоон гарын үсэгтэй болгоно | Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2022.05.01-ны өдрөөс эхлэн иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2023 оны 8-р сард 320 иргэнд тоон гарын үсэг олгосон. Нийт 15292 иргэнд тоон гарын үсэг олгож нийт иргэдийн 38 хувьд олгосон байна. | 70 |
| **Зорилт 5.2. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.** | | | | | | | | |
| 5.2.1 | ЗГҮАХ 4.2.6, ЗДҮАХ-4.2.2 | Сумын ЗДТГ-ын барилгын их засвар хийх | 400.0 | 346.7 | Зураг төсөв хийгдсэн | Засварын ажлын гүйцэтгэл 100 хувь хүрсэн байна | Бугат сумын ЗДТГ-ын барилгын их засварыг ОНТ-ийн 300 сая төгрөг, Гурванбулаг сумын ЗДТГ-ын урсгал засварыг ОНТ-ийн 50 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэлээ. | 100 |
| **ЗУРГАА. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ** | | | | | | | | |
| **Зорилт 6.1. Батлан хамгаалах бодлого, зорилтыг хэрэгжүүлж, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх, дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжих нөхцөлийг хангах, хүүхэд залуучуудад эх оронч үзэл** | | | | | | | | |
| 6.1.1 | МУХТЖҮЧ-6.4.3, ЗГҮАХ-4.3.11, ЗДҮАХ-4.3.9 | Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, техник, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх | 25.0 | 2.0 | - | Тоног төхөөрөмжөөр хангасан байна | 2023 оны эхний 5 сарын байдлаар тус аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сургалтыг 122 удаа буюу 162 цаг зохион байгуулж, 4051 иргэн хамрагдаж, 2200 тараах материал хүргэсэн байна. 2023 оны 4, 5 дугаар сард аймгийн Засаг даргын 2023 оны А/311 дүгээр захирамж, Гамшгаас хамгаалах хяналт шалгалт, сургалт зохион байгуулах удирдамжийн хүрээнд Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтран 2 ажлын хэсгийг томилгоожуулан 16 сум, 1 тосгонд ажиллаж, ангиллын сургалт /удирдах ажилтан, ажилтан, мэргэжлийн анги, иргэд, сурагчид/-ыг зохион байгуулж, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын бэлтгэл, бэлэн байдлыг шалгаж, зөвлөгөө зөвлөмжийг хүргэв. 06 дугаар сард Улсын Онцгой байдлын газар, аймгийн Онцгой байдлын газар хамтран Булган аймгийн стратегийн команд штабын сургуульд 16 сум 1 тосгоны 100 гаруй албан хаагч оролцсон. | 100 |
| **Зорилт 6.2. Хууль сахиулах салбарын бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.** | | | | | | | | |
| 6.2.1 | ЗДҮАХ-4.3.5 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих 439 дүгээр хаалттай ангийн спорт заалны барилга | 491.3 | 491.3 | Ажлын явц 70 хувь | Барилгыг дуусгаж ашиглалтад бүрэн оруулна | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 439 дүгээр хорих ангийн хашаанд спорт заалны барилгын ажлын явц 85 хувьтай явагдаж байна. | 85 |
| 6.2.2 | МУХТЖҮЧ-7.4.1, ЗГҮАХ-4.3.2, ЗДҮАХ-4.3.1 | Аймгийн төвийн хяналтын камерыг стандартын шаардлага хангасан сүүлийн үеийн камераар засварлаж, шинэчлэх | 100.0 | 100.0 | Гүүрэн гарцны 5 цэгт камерын сервер хуучирч, 3 гэмтэлтэй | Булган аймгийн нутаг дэвсгэрт байрлах 5 гүүрэн гарцны хяналтын камерын серверийг бүрэн шинэчилнэ | 1,6 дугаар багт шилэн кабел татаж бэлдсэн. Залуус хороололд 6 ширхэг камер байрлуулсан. Ааймгийн төв рүү орох 2 талын зам дээр машины дугаар илрүүлэгч байршуулах 2 ширхэг шон байрлуулаад байна. | 70 |
| **ДОЛОО. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ** | | | | | | | | |
| **Зорилт 7.1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарыг бүс нутгийн түвшинд тогтвортой хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7.1.1 | МУХТЖҮЧ-8.1.11, ЗГҮАХ-3.6.1, ЗДҮАХ-5.2.1 | Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл 99.7 км авто зам барих | 28,629.2 | 16,855.5 | Гүйцэтгэгчээр "РЭС" ХХК шалгаран гэрээ байгуулсан. Газар шорооны ажил эхэлсэн | Орхон-Хишиг-Өндөр сум чиглэлийн 31.08 км авто зам барина | Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 99 км хатуу хучилттай авто замын ажлын үргэлжлэл 2022 онд эхэлсэн бөгөөд энэ оны ажлын гүйцэтгэл ажил гүйцэтгэх графикийн дагуу хэвийн явагдаж байна. 2023 онд 31 км хатуу хучилттай авто зам баригдах ба хөрөнгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн. Ажлын явц 34.0 хувьтай байна. | 50 |
| 7.1.2 | МУХТЖҮЧ 6.4.4, ЗГҮАХ 5.1.1, ЗДҮАХ-2.3.5 | Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах | 850.0 | 61.4 | Зураг төсөвтэй, 500.0 сая төгрөгийг ОНТ-өөс шийдвэрлэсэн | Үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна | Байгаль орчинд ээлтэй шахмал түлшний үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах гүйцэтгэгчээр Эс Ай Си Эй ХХК шалгарч 08 дугаар сарын 17-нд гэрээ байгуулан 12 дугаар сард хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | 30 |
| 7.1.3 | МУХТЖҮЧ-8.3.8, ЗГҮАХ-3.3.10, ЗДҮАХ-5.1.2 | Түүхий эдийн захын дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ /Орхон сум/ | 300.0 | 300.0 | Зураг төсөв хийгдсэн | Түүхий эдийн захын бүтээн байгуулалтын ажил 50 хувьд хүрсэн байна | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд хэрэгжихээр хөрөнгө оруулалт тусгагдсан боловч 2023 оны төсөвт 300,0 сая төгрөг тусгагдан. Цахилгаан хангамжийн хаалттай станц, ус дулаан дамжуулах төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна. | 50 |
| 7.1.4 | МУХТЖҮЧ-8.3.6, ЗГҮАХ-3.3.1, ЗДҮАХ-2.2.11 | Булган, Хутаг-Өндөр суманд тус бүр 500 тонны багтаамжтай механиксан зоорь барих | 980.0 | - | Аймгийн хэмжээнд 200 тн багтаамжтай механикжсан зоорь байна | Ашиглалтад оруулна | 2024 онд хэрэгжинэ. | ХБ |
| 7.1.5 | МУХТЖҮЧ-8.1.10, ЗГҮАХ-6.2.7, ЗДҮАХ-3.4.6 | Булган сумын гэр хорооллын гудамж талбайг үе шаттайгаар гэрэлтүүлэгтэй болгох | 850.0 | 1,250.0 | 4, 6 дугаар багт гэрэлтүүлэг хийсэн | Гэр хорооллын гэрэлтүүлгийг 15 хувьд хүргэнэ | 4 дүгээр багийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийг хийхээр тендер зарлаж, ажлыг эхлүүлсэн. 2023 онд Цагаан хаалганаас Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хужир толгойгоос отоглох цэг хүртэлх авто замын гэрэлтүүлэг, орон сууцнуудын гадна гэрлэн чимэглэлийг ашиглалтад оруулаад байна. | 100 |
| 7.1.6 | МУХТЖҮЧ-4.2.5, ЗГҮАХ-4.1.5, ЗДҮАХ-5.1.7 | Багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ бий болгох | - | - | 20 байршилд үүрэн холбооны сүлжээнд холбогдсон | Мобиком, Юнителийн сүлжээтэй болсон байна | Бугат-1, Дашинчилэн-2, Могод-1, Сайхан-1, Тэшиг-1, Хангал-1, Хишиг-Өндөр-1, Хутаг-Өндөр-3 нийт 11 байршилд үүрэн холбооны сүлжээний антен байршуулах зориулалтаар газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд тусгаж, газар олголтыг хийгээд байна. | 70 |
| 7.1.7 | ЗГҮАХ-6.2.13, ЗДҮАХ-5.1.1 | Булган, Орхон суманд бетон зуурмагийн үйлдвэр байгуулах | 1,400.0 | - | Хувийн хэвшлийн 1 бетон зуурмагийн үйлдвэртэй | Хайрга дайрганы үйлдвэрийг байгуулна | Бетон зуурмагны үйлдвэр ажиллаж байна. | 70 |
| 7.1.8 | ЗДҮАХ-2.3.4 | Булган суманд стандартын шаардлага хангасан өндөр зэрэглэлийн зочид буудал барьж шинээр ашиглалтад оруулах | 1,000.0 | - | 70 хувьтай | Зочид буудлын тожижилтын ажил гүйцэтгэнэ | Аймгийн Засаг даргын 2021 оны А/162 дугаар захирамжаар "Супрема бүтик лоджес" ХХК-нд 10814 м.кв газрыг зочид буудлын зориулалтаар газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ 64.8 сая төгрөгийг төлүүлэн газар эзэмших гэрээ, гэрчилгээг олгосон. Зочид буудлын барилгын ажил 68.0 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. | 70 |
| **Зорилт 7.2. Бүс нутгийн байгалийн баялаг, өвөрмөц тогтоц, газарзүйн байршил, түүх соёлын дурсгал зэрэг жуулчдын татах байдалд тулгуурлан аялал жуулчлалыг бүсчилэн хөгжүүлж, эдийн засгийн хүртээмжийг** | | | | | | | | |
| 7.2.1 | ЗГҮАХ | Хадлангийн талбайг сэргээх "Борбулан" төсөл | 300.0 | - | - | Төслийг үргэлжлүүлнэ | Баяннуур сумын Бор булангийн хадлангийн талбайг сэргээх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 4 дэх удаагийн тендер Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд зарлагдаж, "Усны барилга" ХХК-тай 2,934,691,087 төгрөгийн гэрээ байгуулсан. | 30 |
| | | | | | | | | **79.0** |

**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**